Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а" дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтын 1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 317 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ЗГХЭГ/201801013 дугаар гэрээт Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Бямбадорж -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Г.Бат-Эрдэнэ -Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын барилгын хяналтын инженер

Гишүүдэд:
М.Мандахжүү -Архивын тасгийн дарга
Ц.Амарсанаа -Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын байцаагч, ахмад
Б.Мөнхдэмбэрэл -Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч
Р.Пүрэвдорж -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
Б.Бээжин -"Алтай-Улиастай эрчим хүчний систем" ТӨХК-ийн Үйлдвэрлэл эрхлэсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер
П.Нямдаваа -Эрдэнэ сумын Засаг дарга
Б.Буянзаяа -Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын дарга
Ч.Нарандэлгэр -"Барилга байгууламж" ХХК-ийн захирал
Н.Алтанхуяг -"Ашид гэгээн өргөө" ХХК-ийн захирал

2.Барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн

бүрдлийг хүлээн авч үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийг хийж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Эрдэнэ сумын Засаг дарга (П.Нямдаваа)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/533 Алтай хот

Гэрээ сунгах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6 дахь заалт, Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 21 дэх хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж буй Баян-Уул, Жаргалан, Шарга, Хөхморьт сумдын жишиг гудамж бий болгож, тохижуулах ажлын гэрээний хугацааг сунгаж, ажлыг улсын комисст хүлээлгэж өгөх хугацааг хавсралтаар тогтоосугай.

2.Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, барилга угсралтын ажлын чанарт хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-т тус тус даалгасугай.

4.Захирамж гарсантай холбогдуулан 2018 оны А/539 дүгээр захирамжийн 2 дахь хавсралтад заасан 2, 5, 6, 7 дугаар дахь заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021762

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 11 өдөр Дугаар А/534 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 07 сарын 17-ны өдрийн 07 дугаартай тогтоолоор батлагдсан Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх 8.000.000 (найман сая) төгрөгийн өртөгтэй Төгрөг сумын 0.4 кв-ын цахилгааны шугамын ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Төгрөг сумын Засаг дарга (Л.Алтангэрэл)-д олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Төгрөг сумын Засаг дарга (Л.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (П.Баасан)-нд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021708

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 14 өдөр Дугаар А/535 Алтай хот

Архи согтууруулах ундаа худалдах
түүгээр үйлчлэхийг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 29.1.6-ийн "ж" дэх заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн албаны 2019 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлага зохион байгуулагдахтай холбогдуулан 2019 оны 10 дугаар сарын 14-нөөс 16-ны өдрүүдэд Есөнбулаг сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2. Хориглосон өдөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах, нэгдсэн болон тусгай арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Болдсайхан), Есөнбулаг сумын Засаг дарга (Ш.Дагва) нарт тус тус даалгасугай.

3. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж, дүнг 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр танилцуулахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Баттайван)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021712

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 14 өдөр Дугаар А/536 Алтай хот

Халиун сумын төвийг төвлөрсөн
дулааны нэгдсэн системд холбох ажилд хяналт
шалгалт хийх ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35.1.1, 35.1.2 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Халиун сумын төвийг төвлөрсөн дулааны нэгдсэн системд холбох ажлын гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт гаргах ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга: М.Батсуурь -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг -Газрын харилцаа, барилга хот байгуулатын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Ж.Мөнхчимэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Б.Лхагва-очир -Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

Б.Мөнхдэмбэрэл -Аймгийн мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Д.Отгонжаргал -Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Т.Алтансүх -Халиун сумын Засаг дарга

С.Оюунчимэг -Халиун сумын Засаг даргын Тамгын газрын дарга

2.Барилга байгуулалмжийн ажлын гүйцэтгэл, баримт бичигт хяналт шалгалт хийсэн ажлын үр дүнг 2019 оны 10 дугаар сарын 25-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга (М.Батсуурь)-т тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4.doc

021785

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 14 өдөр Дугаар А/537 Алтай хот

Бүгд Найрамдах Солонгос Улсад
томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдыг чадавхжуулах өндөр хөгжилтэй орнуудтай харилцааг өргөжүүлж, төрийн болон аж ахуйн нэгжийн дэвшилтэт технологи, сайн туршлагыг судлах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Бат-Очирыг 2019 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Солонгос Улсын Бусан хотод нутгийн захиргааны байгууллагатай уулзаж, туршлага судлах сургалтад сумын Засаг дарга нартай оролцуулахаар томилсугай.

2.Сургалтад хамрагдсан илтгэх хуудсаа ирсэн өдрөөс хойш 5 хоногийн дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн (П.Бат-Очир)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Д.ДАВААДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021714

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/538 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдсэн "Алтай хотын гэр хорооллын өрхийг 2 тарифт цахилгааны тоолууруар хангах "ГААОНӨГ/201901019 дугаар гэрээтэй ажил гүйцэтгэгдэж дууссан тул тус ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга:	Н.Энхбаяр	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Д.Алтанцэцэг	-"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн борлуулалтын албаны дарга
	П. Баяржаргал	-"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Тоолуур хэмжүүрийн инженер
	Д.Отгонжаргал	-Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч
	Б.Лхагва-Очир	-Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн
	Ц.Ариунжаргал	-Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн цахилгааны улсын байцаагч
	Б.Балдорж	-Орон өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	У.Дэлгэрбаяр	-"Зэт Ди Эн Смарт Энержи" ХХК-ийн менежер

2. Тоног төхөөрөмжийг хүлээн авч ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч үр дүнг танилцуулахыг комиссын дарга (Б.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн тухайн байгууллагатай хамтран хөрөнгийн бүртгэл хийж, өөрчлөлтийг бүртгэж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК (А.Пүрэвсүрэн)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4.doc

021705

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/539 Алтай хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ГААОНӨГ/201907053 дугаартай Мал эмнэлгийн гэрчилгээний систем нэвтрүүлэх тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Н.Сандаг	-аймгийн Мал эмнэлгийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Р.Бүрэнбаясах	-Мал эмнэлгийн газрын Зооноз, халдварт өвчин тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Э.Бямбаа	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн бус байгууллага, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
	З.Мөнхнасан	-Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
	Ш.Соронзонболд	-"Альфа зууч" ХХК-ийн менежер

2. Мал эмнэлгийн гэрчилгээний систем нэвтрүүлэх тоног төхөөрөмжийг гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, барааны тоо хэмжээтэй нийцүүлэн хянаж авах, холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Н.Сандаг)-т үүрэг болгосугай.

3. Хүлээн авсан тоног төхөөрөмжийг орон нутгийн өмчид бүртгэн авч Мал эмнэлгийн газартай хамтран хөрөнгийн хөдлөлт, өөрчлөлтийг хийж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Н.Сандаг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4.doc

021730

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/540 Алтай хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоолын 3.8 дахь заалт, Улсын онцгой комиссын 2019 оны 8 дугаар 19-ний өдрийн өргөтгөсөн хуралдаанаар "Аймаг сумын хэмжээнд мал мах бэлтгэх, нийлүүлэх ажлыг эрчимжүүлэх" чиглэлээр өгөгдсөн үүрэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 01/1046 албан бичгээр ирүүлсэн чиглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн 2019 оны намар, 2020 оны хаврын хэрэгцээт махны нөөцийг бүрдүүлэхэд зориулж мах бэлтгэх, нийлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Ганбат	-аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Б.Баян-Эрдэнэ	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Н.Сандаг	-Мал эмнэлгийн газрын дарга
	Б.Түмэнбаатар	-Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Т.Мөнхнасан	-Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга
	С.Гантулга	-Авто тээврийн төвийн дарга
	Б.Элбэгжаргал	-Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
		-Сумдын Засаг дарга нар
Нарийн бичгийн дарга:	П.Мөнхзаяа	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнсний үйлдвэрлэл, нийтийн хоол, худалдаа хариуцсан мэргэжилтэн

2. Дээрх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсэг (Ж.Ганбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc
021728

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/541 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 104 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжилт хийгдэх ГААОНӨГ/201907044 дугаартай Хүүхдийн паркын тоглоомын тоог нэмэгдүүлэх (2 ширхэг тоглоом суурилуулах) ажлыг "М.Одням ахлагчтай иргэдийн бүлэг"-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажилллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)–т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc
021717

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/542 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 103 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжилт хийгдэх ГААОНӨГ/201907044 дугаартай Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх (2 ширхэг тоглоом суурилуулах) ажлыг "Дашрэнцэн ахлагчтай иргэдийн бүлэг"-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт,ашиглалтын байдалд хяналт тавьж ажилллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)–т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021720

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/543 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн ГААОНӨГ/201907047 дугаар гэрээтэй "Авто замын гэрлэн дохио, камер суурилуулах ажил", ГААОНӨГ/201907042 дугаар гэрээтэй "Цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн ажил" тус тус гүйцэтгэгдэж дуусан тул дээрх ажлуудыг хүлээн авч ашиглалтад оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Д.Энхчимэг	-Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	М.Мөнхцэцэг	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн байгууламж хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Д.Отгонжаргал	-Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч
	Л.Мягмарсүрэн	-Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
	Б.Балдорж	-Орон Өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Т.Ууганжаргал	-Иргэдийн бүлгийн ахлагч

2. Авто замын гэрлэн дохио, камер, болон цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжийг гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, барааны тоо хэмжээтэй нийцүүлэн хянаж авах, холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Д.Энхчимэг)-т үүрэг болгосугай.

3. Хүлээн авсан тоног төхөөрөмжийг орон нутгийн өмчид бүртгэн авч Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран хөрөнгийн хөдлөлт, өөрчлөлтийг хийж, хяналт тавьж ажиллахыг орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (Ш.Дагва)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021723

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 14 өдөр Дугаар А/544 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 109 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжилт хийгдэх ГААОНӨГ/201907048 дугаартай Алтай хотын хатуу хучиллттай авто зам дагуу тэмдэг, тэмд:эглэгээ хийх ажилд "Д.Болормаа ахлагчтай иргэдийн бүлэг"-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Цагдаагийн газар (Д.Болдсайхан)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Болдсайхан)-т үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажилллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)–т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNB-3A-4.doc

021737

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20 19 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/545 Алтай хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 06 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/130 дугаар захирамжийн 1 дэх заалтын "Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т" гэснийг "Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль (М.Банзаагаяа)-д" гэж өөрчилсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Алтайбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021734

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/546 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", "в" дэх заалт, 29.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 62, 63, 64 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас сум, тосгоны эмийн эргэлтийн сан татан буулгах шийдвэр гарсантай холбогдуулан татан буулгах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Засаг даргын Тамгийн газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: -Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүд:
-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
-Эрүүл мэндийн газрын Удирдлага, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга
-Эрүүл мэндийн газрын эмийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
-Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга нар (Эмийн эргэлтийн сангийн хяналтын зөвлөлийн дарга)
-Сумын Засаг дарга нар (Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөлийн дарга)
-Сум, тосгоны Эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн дарга нар
-Сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нар

2.Татан буугдаж буй эмийн эргэлтийн сангуудын дуусгалтын баланс гаргах, өр, авлагыг барагдуулж, хөрөнгө эзэмшигчид нь худалдан борлуулах, балансаас балансад шилжүүлэх, татан буулгах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Б.Алтайбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021732

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/547 Алтай хот

Шарга сумд сур харвааны талбай
байгуулах хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 8.2.1, 8.1.6 дахь хэсэг, Алтайн 1000 харваач хөтөлбөрийн 3.3.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 10 сарын 2-ны 21 дэх хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Алтайн-1000 харваач” хөтөлбөрийн хүрээнд Шарга сумд 3 зурхай бүхий сурын харвааны талбай байгуулахад зарцуулагдах зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Талбай хийхэд шаардагдах 6000000 (зургаан сая) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч. Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Алтайбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

021776

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/548 Алтай хот

Есдүгээр цэцэрлэгийн тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.4 дэх заалт, аймгийн Боловсрол соёл урлагийн газрын санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Есөнбулаг сумын Оргил багт байрлах есдүгээр цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай сунгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Алтайбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021775

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/549 Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах явуулах журам"-ын 9.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2019 оны А/470, А/482, дугаар захирамжаар зарлагдсан газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга: Ж.Мөнхболд -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Удирдлагын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхтуяа-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Гишүүдэд: П.Бат-Очир -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомжийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Ж.Мөнхчимэг -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

М.Батсуурь -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж явуулахыг комисс (Ж.Мөнхолд)-т, шалгаруулалтын үр дүнг танилцуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4.doc

021769

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 19 өдөр Дугаар А/550 Алтай хот

Гэрээ сунгах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 35.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилтээр хэрэгжиж буй Чандмань сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын өргөтгөлийн БСШУСЯ/201801237 дугаар гэрээт барилгын угсралтын ажлыг үргэлжлүүлж улсын комисс хүлээлгэн өгөх хугацааг хавсралтаар баталж, гэрээ сунгах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т олгосугай.

2. Ажил гүйцэтгэгх хугацаа, ажлын тоо хамжээ, барилга угсралтын ажлын чанарт хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021749

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 сарын 17-ны өдрийн 019/95 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ДЮА0042

2018 ОНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГЭРЭЭ СУНГАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжих засварын ажлын нэр, хүчин чадал, байршил	Гэрээ сунгах хугацаа	Гэрээ байгуулсан дүн	Санхүүжсан дүн /сая.төг/	Ажлын гүйцэтгэл */бодит гүйцэтгэл, хувийг бичнэ./*	Тайлбар /үр дүн/	Гэрээ сунгах хүсэлт ирүүлсэн эсэх	Гүйцэтгэгч хугацаандаа амжаагүй, гэрээ сунгах болсон шалтгаан	Гүйцэтгэгч компаниийн нэр
1	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Говь-Алтай, Чандмань сум/	2019.10.17-2019.10.25	1,988.5	1784.5	90%	Барилгын дотор заслын ажил хийгдэж байна.	2019 оны 10 сарын 04-ний өдрийн 019/95 дугаар албан бичгээр гэрээ сунгах хүсэлт ирүүлсэн.	Цахилгааны хэлбэлзэлээс болж ажил удааширсан.	"Топ фасад монголиа"ХХК

___oOo___

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/551 Алтай хот

Газар эзэмшүүлэх төсөл сонгон
шалгаруулалт зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 248, 2016 оны 10 дугаар тогтоол, 2019 оны 202 дугаар тогтоол, Барилга, хот, байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд 2 нэгж талбарт нийтийн орон сууцны зориулалтаар газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зарлах газрын хэмжээ, зориулалтыг 1 дүгээр хавсралтаар, байршлыг 2-3 дугаар хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруултыг 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021779

Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 14 өдрийн 357 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ДЮА0042

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАН ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ, ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛЛАЛТ ЯВУУЛАХ ХУГАЦАА, ГАЗРЫН АНХНЫ ҮНЭ

№	Газрын байршил	Зориулалт	Талбайн хэмжээ /м2/	Дуудлага худалдааны анхны үнэ /мян.төг/
1	Баянхайрхан баг Солонго хороолол	Хаус хороолол	10621	106210.0
2	Баянхайрхан баг Солонго хороолол	Хаус хороолол	10621	106210.0

__o0o__

Гэрээ сунгах эрх олгох тухай

Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх

ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 820800 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Солонго хороолол



Зургийн масштаб 1:2 000 (1 сантиметрт 20 метр багтана)

Аймгийн Засаг даргын
2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн
А/551 дугаар захирамжийн 2-р хавсралт

Д!ОА0042

Огноо: 2019-10-17

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5137927.937	287130.817	46.00	1-2
2	5137965.323	287104.016	230.89	2-3
3	5138099.847	287291.668	46.00	3-4
4	5138062.462	287318.469	230.89	4-1

Талбайн хэмжээ: 10621.0 квадрат метр

Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх

ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 820800 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Солонго хороолол



Зургийн масштаб 1:2 000 (1 сантиметрт 20 метр багтана)

Аймгийн Засаг даргын

20 19 оны 10 дугаар сарын 10 -ны өдрийн

A/551 дугаар захирамжийн 3 -р хавсралт

ДІСА0042

Огноо: 2019-10-17

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5137979.863	287094.691	46.00	1-2
2	5138017.249	287067.890	230.89	2-3
3	5138151.774	287255.542	46.00	3-4
4	5138114.388	287282.343	230.89	4-1

Талбайн хэмжээ: 10621.0 квадрат метр

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/552 Алтай хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
дахин дуудлага худалдаа зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Барилга, хот, байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд аймгийн 1 нэгж талбарт газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг дахин зарлан явуулах газрын хэмжээ, зориулалт, дуудлага худалдааны анхны үнийг 1 дүгээр хавсралтаар, байршлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны шалгаруултыг 2019 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021770

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/638 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА, ХУДАЛДАА ЗАРЛАН ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ, ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ

№	Газрын байршил	Зориулалт	Талбайн хэмжээ /м2/	Дуудлага худалдааны анхны үнэ /мян.төг/
1	Харзат баг Нэгдсэн эмнэлэгийн зүүн талд	Уурын зуухны зориулалтаар	8000	80000.0

__o0o__

Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх
ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Аймгийн Засаг даргын
20 19 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн
А/552 дугаар захирамжийн 2-р хавсралт

ДІОА0042

Нэгж талбарын дугаар: 820800 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг

Огноо: 2019-10-17

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5139411.077	289595.706	24.74	1-2
2	5139434.228	289604.443	83.62	2-3
3	5139454.346	289685.609	37.50	3-4
4	5139463.379	289722.002	70.38	4-5
5	5139396.195	289742.976	68.90	5-6
6	5139376.914	289676.827	49.79	6-7
7	5139414.123	289643.744	16.98	7-8
8	5139403.335	289630.637	9.32	8-9
9	5139395.415	289635.547	6.51	9-10
10	5139392.029	289629.990	6.66	10-11
11	5139386.340	289633.458	24.95	11-12
12	5139376.142	289610.683	38.01	12-1

Талбайн хэмжээ: 8000.0 квадрат метр

Зургийн масштаб 1:2000 (1 сантиметрт 20 метр багтана)

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/553 Алтай хот

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэн өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын захирамжаар гэр бүлийн хэрэгцээнд дундаа газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан хавсралтад дурьдсан 4 иргэнд үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (Ш.Дагва), Улсын бүртгэлийн хэлтэс (Г.Чүлтэмжамц)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 97 дугаар захирамжийн хавсралтын 78, 2006 оны 261 дугаар захирамжийн хавсралтын 42, 2006 оны 28 дугаар захирамжийн хавсралтын 92,94 дугаарт бүртгэгдсэн холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Газар өмчлөх эрх нь сэргээгдсэн иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

My documents/ZAHNR-3A-4 doc

021001

Аймгийн Засаг даргын 20[illegible] оны [illegible]
дугаар сарын [illegible] өдрийн [illegible] дугаар
захирамжийн хавсралт

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХЭЭ НЭГ ГИШҮҮНДЭЭ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

Д/д	Овог нэр	Ам бүл	Хаяг	Газрын хэмжээ /м2/	Гэр бүлийн хамтын хэрэгцээнд өмчилж авсан				Өмчлөх эрх шилжүүлэн авагчийн овог нэр	Тайлбар
					Огноо	Дугаар	Хавсралтад орсон дугаар	Өмчлөх эрх шилжүүлэгчийн овог нэр		
1	Дэмбэрэл Дашдаваа	4	Баяншанд баг 5-18 тоот	940.0	2015.04.18	97	78	З.Алтанхүү Д.Пүрэвжаргал Д.Бямбаширнэн	Дэмбэрэл Дашдаваа	Нотариатын гэрээ хийгдсэн.
2	Санжжав Сарангэрэл	5	Баяншанд баг 2-5 тоот	625.0	2006.10.12	261	42	Н.Дашдорж Д.Жамбалсүрэн Д.Дорж Д.Бүжинлхам	Санжжав Сарангэрэл	Нотариатын гэрээ хийгдсэн.
3	Баатар Далайням	6	Баяншанд баг 5-13 тоот	1011.0	2006.03.10	28	94	В.Байгалмаа Б.Дулмаа Б.Юмжирдулам В.Нанжид В.Цэвэгсүрэн	Баатар Далайням	Нотариатын гэрээ хийгдсэн.
4	Жанцан Бат-Эрдэнэ	4	Баяншанд баг 11-2 тоот	1018.0	2016.03.10	28	92	Б.Цэрэндолгор Б.Цэдэнпүрэв Б.Мөнхням	Жанцан Бат-Эрдэнэ	Нотариатын гэрээ хийгдсэн.

___oOo___

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/554 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 112 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/201910066 дугаартай Тайшир сумын ундны усны худгийн барилгын засвар, ухаалаг төхөөрөмж суурилуулах ажлыг "Баялаг говь" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Баттайван)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг "Ундарга-Алтай" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (С.Булгантамир)-т үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Баттайван)-т, Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021802

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/555 Алтай хот

Цогт сумын ухаалаг төхөөрөмж
бүхий худгийн барилга барих ажилд
гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 113 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/201910065 дугаартай Цогт сумын ухаалаг төхөөрөмж бүхий худгийн барилга барих ажлыг "Баялаг говь" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Баттайван)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг "Ундарга-Алтай" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (С.Булгантамир)-т үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Баттайван)-т, Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4.doc

021808

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20 19 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/556 Алтай хот

Есөнбулаг сумын гэр хорооллын
4 багийн худгийн хайс хамгаалалтын
ажилд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 110аар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/201910067 дугаартай Есөнбулаг сумын гэр хорооллын 4 багийн худгийн хайс хамгаалалтын ажлыг “Дөл-Өөдөө” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Баттайван)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг “Ундарга-Алтай” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (С.Булгантамир)-т үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Баттайван)-т, Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc
021805

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20 19 оны 10 сарын 28 өдөр Дугаар А/657 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Их говийн тэмээний баяр-2019" наадмыг Алтай хотод 11 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Наадам зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	В.Сүррагчаа	-Аймгийн Засаг даргын зөвлөх
Нарийн бичгийн дарга:	Б.Баян-Эрдэнэ	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Гишүүд:	Б.Алтайбаатар	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Б.Түмэнбаатар	-Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Д.Болдсайхан	-Цагдаагийн газрын дарга
	Н.Сандаг	-Мал эмнэлгийн газрын дарга
	Н.Бямбацогт	-Биеийн тамир, спортын газрын дарга
	Ш.Дагва	-Есөнбулаг сумын Засаг дарга
	Э.Отгонбаатар	-Ардын дуу бүжгийн Алтай чуулгын дарга
	Б.Элбэгжаргал	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	М. Зандраа	-Нийтлэг үйлчилгээ ОНТҮГ-ын дарга
	Ш.Пүрэврагчаа	-"Алтайн хөгжил XXI зуун" төрийн бус байгууллагын төлөөлөгч

Сумдын Засаг дарга нар

3. "Их говийн тэмээний баяр-2019" наадмыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, баярын үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг олон нийтэд сурталчилж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (В.Сүррагчаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Д.ДАВААДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021810